



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН

МАГИСТРАНТ, ДОКТОРАНТУУДЫН
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ
ХУРЛЫН ХУРААНГУЙ

20
25

Магистрант, докторантын эрдэм шинжилгээний хурал

ЭМХЭТГЭЛИЙГ ЭРХЭЛСЭН:

ЭШИГ-ын мэргэжилтэн, доктор, Ж.Дуламсүрэн

МУБИС, Эрдэм шинжилгээ, инновацын албанаас эрхлэв.

Улаанбаатар, 2025 он

Гарчиг

Боловсрол судлал

| | |
|---|----|
| Их сургууль, аж үйлдвэрийн хамтын ажиллагааг дэмжих (түгээх) хөшүүрэг нь их сургуулийн судалгааны үр өгөөжид нөлөөлөх нь <i>Жаргалсайхан Намуударь</i> | 2 |
| Бага ангийн багшаар бэлтгэгдэж буй оюутнуудын орон зайн суурь чадварын судалгаа <i>Алтай Нэргүй</i> | 2 |
| Ахлах, дунд ангийн таслалтын шалтгаан нөхцөлийн шинжилгээ (PISA үнэлгээний ST267, ST265 шалгууртай харьцуулсан үр дүн) <i>Балдан-Очир Хашчулуу</i> | 3 |
| Эцэг эхийн хандлага, оюутнуудын сурах зорилгод нөлөөлөх хүчин зүйлсийн судалгаа <i>Chaolumenqiqige</i> | 4 |
| Өвчтөний өвчиндөө хандах хандлагын судалгаа <i>Ганхуяг Лхамсүрэн</i> | 4 |
| “Эцэг эх болон үе тэнгийнхний ээнэгшлийн асуумж”-ын аргаар сургуулийн дотуур байранд амьдардаг өсвөр насны хүүхдийг судалсан судалгаа <i>Nariguna</i> | 5 |
| Бүлгийн орчны агаарын чанарын судалгаа <i>Дашням Хажидмаа, Ган-Од Мөнхжин</i> | 6 |
| Аутизмын хүрээний эмгэгтэй 4-5 настай хүүхдийн нийгэмшихүйн чадварыг дэмжих нь <i>Лхамсүрэн Энхмаа</i> | 6 |
| Суралцагчдын уншиж ойлгох чадварыг дэмжих арга зүй боловсруулан туршсан нь <i>Мөнхтөр Чойжамц</i> | 7 |
| Багш мэргэжлээр суралцагчдын сэтгэл хөдлөлийн оюун ухаан, стресс болон эмпати хоорондын хамаарал Тэрбиш Норовсүрэн, Амарсайхан Ичинхорлоо | 8 |
| Дээд боловсролын багшийн дижитал чадамжийн асуудал судалгааны онолын тойм <i>Сурнаа</i> | 8 |
| Сурагчдын шүүн тунгаах чадварын үнэлгээ ба STEM хичээлээр хөгжүүлэх боломж <i>Төмөрбаатар Насантогтох</i> | 9 |
| Хиймэл оюун ухаан, түүний боловсрол дахь хэрэглээ <i>Түмэндэмбэрэл Тунгалагтамир</i> | 10 |

| | |
|--|----|
| Уур амьсгалын өөрчлөлтийн бичиг үсгийн боловсролын судлагдсан байдлын тойм <i>Xiao Quansheng</i> | 10 |
| Түүхийн хичээлээр зураг зүйн мэдлэг, чадвар төлөвшүүлэх арга зүйн асуудалд <i>Одхүү Дашням</i> | 11 |
| Суралцагчдын өөрийн удирдлагатай суралцахуйг интеграцид суурилсан даалгавраар дэмжих нь <i>Давааням Азжая</i> | 11 |
| Азийн зарим улсын уламжлалт гар сүлжмэл урлалыг харьцуулсан судалгаа Чулуунбаатар Батцэцэг | 12 |
| “Эрдэнийн сан Субашид”-ийн сурган хүмүүжүүлэх үзэл санааны судалгаа <i>Gegentana</i> | 13 |
| Case studies of the professional development of efl teachers context the self as source1 <i>Cha Na</i> | 13 |
| Хятад хэлний бичих дадал хичээлд сургалтын зарим аргыг хэрэглэж туршсан үр дүн (МУИС-ийн ББС-ийн хятад хэлний орчуулагч мэргэжлийн ангийн жишээгээр) <i>Төмөрбаатар Энэбиш</i> | 15 |
| Бага ангийн багш нар сурагчдын өдрийн тэмдэглэлийг уншихтай холбоотой зөрчлийн судалгаа <i>Zhang Mingzhi</i> | 15 |
| Хүмүүнлэг | |
| Мөнх хааны гэрэлт хөшөөний бичээсийн зохиомж, уран сайхны шийдэлд хийсэн ажиглалт <i>Батаа Балжин</i> | 17 |
| Үндэсний сурын “нээлтийн харваа” тэмцээний амжилтад хийсэн <i>Энхбаяр Баатарсүрэн</i> | |
| Өс хонзонгийн дүрслэл ба Жангар тууль Сумъяасүрэн Батзориг | 18 |
| Хөгжмийн мэргэжлийн суралцагчдад тулгамдаж буй зарим асуудал (хийл хөгжмийн жишээн дээр) Энх-Амгалан Энхцэцэг | 18 |
| Дөчин дөрвөн хоёрын их цаазын судалгааны уламжлал шинэчлэлийн асуудалд Ганхуяг Эрхэмбаяр | 19 |
| Мөнгөний дарханы чадварын судалгаа Jun Xi | 20 |

| | |
|--|----|
| Монголчуудын улс төрийн соёл, оролцооны зарим асуудал <i>Аюурзана Мөнхцэцэг, Одгэрэл Гэрэлмаа</i> | 21 |
| Монгол хэлний хүндэтгэлийн утгат нэгжийн тухай Yu Quan | 21 |
| Овгийн тамганы танин мэдэхүйн конструкц, тиг хэмжээг шинжих нь (Археологийн олдворын жишээн дээр) <i>Гомбожав Лувсандандар, Раднаабазар Гоцбаяр, Загд Баярмагнай</i> | 22 |
| Аригбөх хааны дүрийн судалгаа <i>Хасбаатар Содбилэг, Р.Гоцбаяр</i> | 22 |
| Байгалийн ухаан | |
| Шилмүүст ойн ангуучин шүрэн цохынхон (coccinellidae) <i>Чинболд Энхзаяа, Ганболд Уранбилэг, Доржсүрэн Алтанчимэг, Чулуунбат Сувдцэцэг</i> | 24 |
| Цайвар хүрэн болон бор хөрсний органик нүүрстөрөгчийн нөөц <i>Ганболд Ууганбат</i> | 24 |
| Монгол орны гардалавчтаны (Chiroptera Blumenbach, 1779) эктопаразит <i>Монголхүү Давааням</i> | 25 |
| Монгол бах / <i>Strauchbufo raddei</i> /-ын генетик олон янз байдал ба филогенетик <i>Рэнцэнжүгдэр Биндэрьяа</i> | 25 |

БОЛОВСРОЛ СУДЛАЛ

Их сургууль, аж үйлдвэрийн хамтын ажиллагааг дэмжих (түгээх) хөшүүрэг нь их сургуулийн судалгааны үр өгөөжид нөлөөлөх нь

Жаргалсайхан Намуударь**
Монгол Улсын Боловсрол Их Сургууль, Боловсрол судлалын сургууль,
Боловсролын удирдлагын тэнхим
namuudari@msue.edu.mn

Хураангуй. Их, дээд сургуулиудын судалгааны чанарыг сайжруулахад их сургууль, аж үйлдвэрлэлийн хамтын ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэхүү судалгаа нь их, дээд сургууль, аж үйлдвэрлэлийн хамтын ажиллагааны дэмжих (түгээх) хөшүүрэг нь, үйл ажиллагаа, үр өгөөжид хэрхэн нөлөөлж буйг судлах зорилготой юм. Уг судалгааны дэвшүүлсэн таамаглалын дагуу дүн шинжилгээ хийсний үр дүн нь дэмжих (түгээх) хөшүүрэг нь мэргэжилтний солилцоо, судалгаа хөгжүүлэлт, энтрепренершип, судалгаа хөгжүүлэлтийн үр дүн арилжаалалт хувьсагчидтай эерэг хамааралтайг харуулсан. Харин мэргэжилтний солилцоо нь их сургуулийн судалгааны үр өгөөжтэй сөрөг, бусад үйл ажиллагаа нь их сургуулийн судалгааны үр өгөөжтэй эерэг хамааралтай болохыг харуулсан. Их, дээд сургуулиуд, аж үйлдвэрийн хамтын үйл ажиллагааны хүрээнд багш, оюутнууд болон аж үйлдвэрийн салбарын мэргэжилтнүүд хоорондоо хамтарсан эрдэм шинжилгээний бүтээл, судалгаа хөгжүүлэлт, гарааны компанийн хөгжил, бүтээгдэхүүний хөгжүүлэлтийн үйл явцад нөлөөлж, илүү үр дүнтэй хамтын ажиллагааг бий болгох шаардлагатай. Их, дээд сургууль болон аж үйлдвэртэй хамтран ажиллагаанд багш, оюутнуудын их сургуулийн судалгааны үр өгөөжид хувь нэмэр оруулахад саад болж буй хүчин зүйлсийг судлах шаардлагатайг онцолж байна.

Түлхүүр үг: Их, дээд сургууль, аж үйлдвэр, хамтын ажиллагаа, хөшүүрэг, судалгаа, үр өгөөж
Удирдагч: О.Алтангоо, МУБИС

Бага ангийн багшаар бэлтгэгдэж буй оюутнуудын орон зайн суурь чадварын судалгаа

Алтай Нэргүй**
Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Багшийн сургууль,
Бага боловсролын арга зүйн тэнхэм
nergui.a@msue.edu.mn

Хураангуй. Хүний бүтээлч сэтгэлгээ, зохион бүтээх ур чадварыг хөгжүүлэх үндсэн суурь нь орон зайн ур чадвартай салшгүй холбоотой юм. Энэ нь бага ангийн дүрслэх урлаг, технологийн сургалтын чухал хэсэг бөгөөд хүүхдүүдийн орон зай, хэлбэр, хэмжээ, байрлал зэрэг ойлголтуудыг ойлгох, төсөөлөх, бүтээх чадварыг хөгжүүлдэг. Бага ангийн багшаар бэлтгэгдэж байгаа оюутнуудын хувьд дүрслэх урлаг, технологийн хичээлээр энэ чадварт суралцсан байх шаардлагатай байдаг. Иймд бага ангийн багш бэлтгэх сургуульд элсэн орж буй оюутнуудын орон зайн суурь чадвар ямар түвшинд байгааг илрүүлэх зорилгоор 80 оюутнаас судалгаа авлаа. Судлаач Миллер ба Бертолайны хүний орон зайн чадварыг шалгахад орон зайн гурван үндсэн хүчин зүйл болох орон зайн харилцаа, орон зайн чиг баримжаа, орон зайн дүрслэлээр тодорхойлно гэдэгт тулгуурлан даалгаврыг боловсруулж үр дүнг тооцов. Даалгавруудыг гүйцэтгэсэн үр дүнг харахад хангалттай сайн 7.5%,

** Докторант

хангалттай 37.5%, дундаж буюу хангалтгүй нийт 45%, маш хангалтгүй даалгавар гүйцэтгэсэн 10% гэж үнэлэгдсэн нь цаашид оюутны орон зайн суурь мэдлэг, чадварыг сайжруулах шаардлагатай байгаагаас гадна даалгавар тус бүрд анализ хийхэд зарим энгийн биет, дүрсийг дүрслэх чадвар тааруу байгаа нь судалгааны үр дүнгээс харагдлаа.

Түлхүүр үг: Орон зайн баримжаа, орон зайн дүрслэл, биетийн эргэлт, дүрслэх чадвар
Удирдагч: З.Баярмагнай, Ч.Байгалмаа, МУБИС

**Ахлах, дунд ангийн таслалтын шалтгаан нөхцөлийн шинжилгээ
(PISA үнэлгээний ST267, ST265 шалгууртай харьцуулсан үр дүн)**

Балдан-Очир Хашчулуу**
Монгол Улсын Боловсрол Их Сургууль, Боловсрол судлалын сургууль,
Боловсролын удирдлагын тэнхим
hashchuluub@gmail.com

Хураангуй. Сургуулийн нийгмийн ажилтны өдөр тутмын үйл ажиллагааны нэг хэсэг нь тухайн өдрийн сурагчдын ирцийн бүртгэлтэй танилцах, эрсдэлт бүлгийн суралцагчийн таслалтын шалтгаан нөхцөлийг тодорхойлох, багш эцэг, эх асран хамгаалагч нартай холбогдож нийгмийн ажлын зөвлөгөө интервенц үзүүлэх билээ. Ангийн ирцийн анализ хийхдээ багш-суралцагч, суралцагч-суралцагчийн хоорондын харилцаа таслалтын шалтгаан нөхцөлд нөлөөлөх хамаарал бий эсэхийг тодорхойлохын тулд 2022 онд Монгол улс анх удаа хамрагдсан PISA олон улсын үнэлгээний Багш суралцагчийн хоорондын харилцаа, Сургуульд хандах хандлагын 2 шалгуурын англи хувилбарыг орчуулан ашиглаж 97 дугаар сургуулийн 6-12 дугаар ангийн 61 бүлгийн 538 суралцагчийг хамруулан судалгаа хийлээ. Судалгааны үр дүнд дунд ба ахлах анги, төрөлжсөн сургалт ба энгийн ангийн бүлэг хооронд хандлагын ялгаатай байдал байгааг илрүүлж, зуучлагч хувьсагчдаар дамжуулан SPSS21 программ дээр үл хамаарах Т-тест, хамаарлын болон регрессийн шинжилгээ хийж үр дүнг танилцууллаа.

Түлхүүр үг: Ирц, багш суралцагчийн харилцаа, сургуульд хандах хандлага, таслалт

**Эцэг, эхийн хандлага, оюутнуудын сурах зорилгод
нөлөөлөх хүчин зүйлсийн судалгаа**

Chaolumenqiige**
Монгол Улсын Боловсрол Их Сургууль, Боловсрол судлалын сургууль,
Боловсрол судлал, арга зүйн тэнхим
1043490872@qq.com

Хураангуй. Орчин үеийн мэргэжлийн коллежийн оюутнууд сургалтын зорилгод тохирсон аргыг сонгож буй нь олон чиг хандлагыг харуулж байна. Энэхүү өгүүлэлд Өвөр монголын 300 мэргэжлийн коллежийн сурагчдын санал асуулгад үндэслэн эцэг эхийн хандлага (хүлээлт, дэмжлэг, хяналт) нь сурагчдын суралцах зорилго, тэдний сурах түвшинд хэрхэн нөлөөлж буйг харуулах зорилго тавьсан. Судалгаанаас харахад, эцэг, эхийн өндөр хүлээлт, дэмжлэг зэрэг хяналт нь сурагчдын зорилго, нийцлийн түвшинг үр дүнтэй сайжруулж, гэр бүлийн хүчин зүйлүүдэд нөлөөлдөг болохыг харж

болно. Судалгааны үр дүн нь гэр бүлийн боловсролыг оновчтой болгох, мэргэжлийн коллежийн боловсролын менежментэд практик ач холбогдлоо өгдөг.

Түлхүүр үг: Эцэг, эхийн хандлага, сурахуйн хяналт, мэргэжлийн коллеж, сэтгэл хөдлөлийн дэмжлэг, хүлээгдэж буй менежмент

Удирдагч: М.Мөнхцэцэг, МУБИС

Өвчтөний өвчиндөө хандах хандлагын судалгаа

Ганхуяг Лхамсүрэн*

Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсрол судлалын судлалын сургууль,
Сэтгэл судлал, арга зүйн тэнхим

Lhamaa901120@gmail.com

Хураангуй. Хандлагын талаар олон судлаачид авч үзсэн байдаг ба Поль Ханель хандлага гэдэг нь үнэлж болохуйц аливаа зүйл болон хэн нэгэнд хүний дуртай, дургүй байгаа байдал гэсэн байдаг. Өвчтөний өвчинд хандах хандлага гэдэг нь хүн өвчнийхөө оношны талаар хэрхэн бодож, мэдрэх болон таагүй, үл хайхарсан, эмзэглэсэн байдлаар хүлээн авч байгаа байдал ба тухайн үед гаргаж байгаа зан үйлдэл, харилцаагаар илэрхийлэгддэг сэтгэл зүйн үзэгдэл. Хандлага нь тухайн хүний сэтгэл санаа, зан төлөв, итгэл үнэмшил, нийгмийн орчин, өвчний шинж чанар зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг. Өвчтөн өвчиндөө хэрхэн хандаж байгаагаас шалтгаалан эдгэрэх, даван туулахад нөлөөлөх чухал хүчин зүйл юм. Иймээс бид өвчтөний өвчиндөө хандах хандлагын илрүүлэх (ТОБОЛ) аргаар 98 өвчтөнөөс судалгаа авч ямар хэв шинжийн хандлагатай өвчтөнүүд байгааг илрүүлэх оролдлого хийсэн юм. Өвчиндөө хандах хандлагыг илрүүлэх (ТОБОЛ) аргын онцлог нь өвчиндөө хандах 12 төрлийн хандлагыг үнэлэх боломжийг олгодог. Гэхдээ 12 хандлага хэзээ ч ганц дангаар илэрдэггүй ба олон хэв шинж хүнд давхар илэрч болох бөгөөд аль нэг давамгайлснаар нь тухайн хэв шинж гэж үзэж болно. Бидний судалгааны ажлын хүрээнд Кронбахын альфа коэффициент 0.862 гарсан нь баталгаат чанарын зохих шаардлагыг хангасан гэж үзэж, судалгааны дараагийн шатны үр дүнд боловсруулалт хийсэн болно. Судалгаанд оролцогчдын хувьд холимог хэв шинж 72 хүн, Давамгайлсан нь 22, тодорхойгүй нь 5 хүн байсан. Өвчтөний өвчиндөө хандах хандлагыг арван хоёр хэв шинжийг тус бүр дундаж утгаар нь авч үзвэл “С” буюу хэт мэдрэмтгий, шаналамтгай хэв шинж 12.18, “Р” буюу нухацтай (өвчиндөө хандахдаа эмчийн зааврыг ягштал баримталдаг) хэв шинж 11.39, “Н” буюу сульдамтгай (мэдрэл сульдал) хэв шинж 8.60, “А” буюу тоомжиргүй хэв шинж 8.16, “Т” буюу түгшимтгий хэв шинж 7.59, “З” буюу өөдрөг (өвчнөө үгүйсгэгч) хэв шинж 6.69, “И” буюу биеэ чагнамтгай хэв шинж 6.67, “М” буюу сэтгэлээр унамтгай хэв шинж 6.23, “П” буюу хардамтгай, сэрдэмтгий хэв шинж 5.86, “Д” буюу догшин ширүүн, цухалдамтгай хэв шинж 5.62 “Г” буюу бодитоор ханддаг, тэнцвэртэй хэв шинж 4.56 тус тус байна. Эндээс үзэхэд судалгаанд оролцогчдын хувьд өвчиндөө хандах хандлага нь бусдад чиглэсэн сөрөг хандлага их илэрсэн байна. Тухайлбал, “С” буюу хэт мэдрэмтгий, шаналамтгай хэв шинж өндөр байгаа өвчтөнүүдийн хувьд эмзэг, бусдын өвчний талаарх үнэлгээ болон өөрийн биеийн байдалд хэт мэдрэг хандаж, өвчнийхөө талаар бодож шаналдаг. Харин “Р” буюу нухацтай (өвчиндөө хандахдаа эмчийн зааврыг ягштал баримталдаг) хэв шинжийн өвчтөнүүд өвчнөө хүлээн зөвшөөрөхөөс зайлсхийж, өөрийгөө ажил эсвэл ямар нэг үйл ажиллагаагаар завгүй байлгах, эсвэл өвдсөн байдлаа ил гаргаж бусдаас онцгой халамж хүсдэг, заримдаа өвчнөө хэт их ажил хийж өөрийн өвчнөө халхавчлах хандлагатай. Судалгаанд оролцсон хоол боловсруулах эрхтэн тогтолцооны оноштой нийт 14 өвчтөнүүдийн дунд “С” буюу хэт мэдрэмтгий хандлага илүү илэрч байсан. Энэхүү судалгаа нь өвчтөний өвчиндөө хандах хандлагыг судлах байсан бөгөөд олон хүчин зүйлийн нөлөөгөөр хүмүүс өвчилдөг хэдий ч тухайн хүний сэтгэл зүйн хувийн онцлог ялгаатай байдал,

* Магистрант

урдаас тогтсон аливаа зүйлд хандах хандлага нь ямар өвчнөөр өвчилдөг болохыг тодруулах судлах шаардлага урган гарч байна.

Түлхүүр үг: Өвчтөний хандлага, өвчтөний сэтгэл зүй, ТОБОЛ, өвчтөний өвчиндөө хандах хандлага
Удирдагч: Ц.Баярмаа, МУБИС

“Эцэг, эх болон үе тэнгийнхний ээнэгшлийн асуумж”-ын аргаар сургуулийн дотуур байранд амьдардаг өсвөр насны хүүхдийг судалсан судалгаа

Hariguna*

Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсрол судлалын сургууль,
Сэтгэл судлал, арга зүйн тэнхим
harguna@163.com

Хураангуй. Монголын эрдэмтэн Ц.Баярмаа ээнэгшихүй гэдэг нь асран хамгаалагч болон ихэвчлэн төрүүлсэн эх, нярай хоёрын хооронд үүсэх маш гүн гүнзгий бат бөх холбоо үүсэн хөгжих үйл явц юм гэж үзсэн байдаг. Марлен М Моретти, Майя Пелед нар өсвөр үе бол ээнэгшлийн объект нь эцэг эхээс найз нөхөд, багш зэрэг рүү хэсэгчлэн шилжих чухал үе хэдий ч эцэг, эх нь сэтгэл санааны аюулгүй байдлын “суурь бааз” (secure base), сэтгэл зүйн дэмжлэгийн эх үүсвэр хэвээр үлддэг. Дунд сургуулийн эхний жилүүдэд өсвөр насныхны өөрийн үнэлгээ, дасан зохицох, сэтгэл хөдлөлийн асуудлуудтай тулгардаг ба хүүхэд эцэг эхийн ээнэгшлийн суурь нь сэтгэлзүйн эрүүл мэндэд маш чухал үүрэгтэй. Судалгааны зорилго нь эцэг эхээсээ хол сургуулийн дотуур байранд амьдардаг хүүхдийн ээнэгшлийн чанарыг үнэлэх ба “Эцэг эх болон үе тэнгийнхний ээнэгшлийн асуумж” (Inventory of Parent and Peer Attachment)-ын аргыг ашигласан. Энэ арга нь өсвөр насны хүүхэд ээж, аав болон үе тэнгийнхнийхээ ээнэгшлийн чанарыг үнэлэх ба хятад улсын хэл соёлын онцлогт нийцэн буусан. Бидний судалгаанд ӨМӨЗО-ний дунд сургуулийн 13-17 насны 1-10 жил дотуур амьдарсан 214 эрэгтэй, 267 эмэгтэй нийт 481 оролцогчид хамрагдсан. 3 жил амьдарсан оролцогчид хамгийн ихийг хувийг эзэлж байсан. Судалгаанд хамрагдсан оролцогчдын хувьд харилцаа, итгэл, хөндий байдал гэсэн гурван хэмжүүрийн хувьд хүйсийн ялгаатай байдал эхийн итгэл, үе тэнгийн итгэл, үе тэнгийн харилцаа дэд хэмжээнүүдэд илт ялгаатай статистикийн хувьд ач холбогдолтой байсан (эхийн итгэл 0.046, үе тэнгийнхний харилцаа 0,002, үе тэнгийнхний итгэл 0.003). Хэддүгээр ангид сурдаг эсэхээрээ хоорондоо ач холбогдолтой ялгаа ажиглагдсан. Ялангуяа 9-р ангийн сурагчдын эцэг эх, үе тэнгийнхэнтэй харилцааны холбоо нь 7-р, 8-р ангийн сурагчдаас ерөнхийдөө илүү өндөр байна. Энэ нь анги ахих тусам сурагчид эцэг эх, найз нөхдөдөө итгэх, харилцах зэрэг харилцааны холбооны хэмжээст мэдрэмж нь ач холбогдолтой сайжирч байгааг харуулж байна. Пирсоны шинжилгээний үр дүнд, сурагчдын сургуулийн дотуур байрны хугацаа нь эцгийн “хөндий байдал”-ын хэмжүүр илэрхий сөрөг холбоотой ($r=-0.114$, $p=.012$), мөн эхийн “хөндий байдал”-ын хэмжүүр сөрөг холбоотой ($r=-0.104$, $p=.022$) байсан. “Хөндий байдал”-ын хэмжүүр нь урвуу оноогоор тооцогдож, оноо нь өндөр байх тусмаа аюулгүй ээнэгшилтэй байна гэсэн үг. Өөрөөр хэлбэл сурагчдын эцэг эхтэйгээ харилцах харилцаа илүү ойр дотно болж байгааг илэрхийлж байна гэсэн үг. Эндээс үзэхэд сурагчдын сургуулийн дотуур байранд амьдрах хугацаа уртсах тусам тэдэнтэй эцэг, эх нь багад нь харилцаж хандаж байснаас үүдэлтэй ээнэгшлийн найдвартай, аюулгүй байдлыг мэдэрсэн бол эцэг эхээ ойлгож, тэдний эцэг эхтэй харилцах сэтгэл хөдлөлийн холбоо сайжирч байна гэж үзэж болно. Бид цаашдаа сургуулийн дотуур байранд амьдардаг өсвөр насны хүүхдүүдийн ээж, аав болон үе тэнгийнхнийхээ ээнэгшлийн чанарт эцэг, эхийн хүүхдээ хүмүүжүүлэх хэв маяг хэрхэн нөлөөлдөг болохыг судлах оролдлого хийж байна.

Түлхүүр үг: Ээнэгшил, дотуур байр, өсвөр насны хүүхэд, сэтгэл зүйн аюулгүй байдал
Удирдагч: Ц.Баярмаа, МУБИС

Бүлгийн орчны агаарын чанарын судалгаа

Дашням Хажидмаа^{1,**}, Ган-Од Мөнхжин²

¹ Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсрол судлалын сургууль,
Боловсрол судлал, арга зүйн тэнхим

² Сургуулийн өмнөх боловсролын сургуулийн оюутан
khajidmaa@msue.edu.mn

Хураангуй. Швейцарын IQAir-ийн агаарын чанарын хяналтын байгууллага 2023 оны Дэлхийн агаарын чанарын 6 дахь жилийн тайланг танилцуулсан байдаг. Түүнчлэн APNEК (Asia-Pacific Regional Network for Early Childhood)-ийн “Бага насны хүүхдийн хөгжил”-ийн асуудлаар бүсийн бага хурлыг 2019 онд Вьетнам улсаас санаачлан зохион байгуулсан. Тус хурлаас, “Ханойгоос хүргэх үйл ажиллагааны уриалга 2019”-г гаргасан. Энэхүү уриалгад хүрээлэн буй орчин, бага насны хүүхдийн хөгжил хоорондын уялдаа холбоог чухалчлан, ялангуяа бага насны хүүхдийн хөгжилд тулгарч буй амьдралын орчноос үүдэлтэй эрсдэлийг багасгах замаар тэдний аюулгүй амьдрах, сайн сайхан байдлыг хангах асуудлыг хөндөж, эдгээр чиглэлээр дэлхий нийтэд уриалсан байдаг. Энэ уриалга дор бид нэгдэж, хүүхдийн эрүүл амьдарч, өсөж хөгжих орчинг тэдэнд ээлтэйгээр шийдэх нэг шийдэл бол бага насны хүүхдийг бохир агаараас ангид байлгахын төлөө бүгд зорилго нэгтэй хамтрах явдал юм. Хэдийгээр агаарын бохирдлын эсрэг тэмцэж, хүүхдийг бохир агаараас хамгаалах чиглэлээр олон бодлого, зөвлөгөө зөвлөмжүүд гарч байгаа хэдий ч бодит байдалд хэрэгжиж, үр дүнгээ өгөх нь хязгаарлагдмал төдийгүй олон асуудал дагуулсаар байна. Иймд бид энэхүү судалгаагаар цэцэрлэгийн анги бүлгийн дотор орчны агаарын чанарын /ДОАЧ/ индексийг судалж, эрсдэлийг тодорхойлж энэ эрсдэл нь хүүхдийн хөгжилд хэрхэн нөлөөлж байгаа, эрсдэлийн түвшинг багасгах арга замыг эрэлхийлэхийг зорилоо. Цэцэрлэгт хамрагдаж буй бага насны хүүхэд өдрийн 24 цагийн 80-90 хувийг цэцэрлэгийн орчинд өнгөрөөж байна. Судалгаанд, AirVisual Pro төхөөрөмж ашиглаж, үр дүнг аналитик судалгааны аргаар тооцсон үр дүнг танилцуулж байна. Судалгааны үр дүнд тухайн нэг бүлэгт дунджаар 35 хүүхэд байгаа нь нүүрсхүчлийн хийн агууламж өндөр болоход нөлөөлж байгаа, мөн агаар цэвэршүүлэгч хэрэглээгүй цэцэрлэгт PM2.5 тоосны бохирдол дунджаар 133 мкг/м³ хэмжигдсэн байна. Харин агаар цэвэршүүлэгч суурилуулсан цэцэрлэгүүдийн дотоод орчинд PM2.5 тоосны бохирдол дунджаар 42 мкг/м³ хэмжигдсэн нь цэвэршүүлэгч хэрэглээгүй ангиас 3.1 дахин бага үзүүлэлттэй байна. Түүнчлэн судалгааны үр дүнгээс дүгнэхэд, дотор агаарын чанар зөвшөөрөгдөх хэмжээнээс 1.5 дахин бохирдолтой байгаа тул дотоод агаарын чанарыг сайжруулах нь эн тэргүүний чухал асуудал болоод байна.

Түлхүүр үг: Агаарын бохирдол, агаарын чанарын стандарт
Удирдагч: Ш.Цэрэннадмид, МУБИС

Аутизмын хүрээний эмгэгтэй 4-5 настай хүүхдийн нийгэмшихүйн чадварыг дэмжих нь

Лхамсүрэн Энхмаа*

Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсрол судлалын сургууль,
Боловсрол судлал, арга зүйн тэнхим
lenkhmaa44@gmail.com

Хураангуй. Бага насны хүүхдийн боловсролд манай улсаас гадна дэлхийн олон улс орнууд ихээхэн анхаарч алсын хараа, боловсролын зорилгодоо тусган хүний хөгжилдөө анхааран ажиллаж байна. Энэхүү зорилтын хүрээнд улс орон бүр тэгш хүртээмжтэй боловсролыг чухалчлан ажиллаж байгаа

хэдий ч боловсролын гадна үлдэж буй хүүхдүүд байсаар байгаа юм. 2019 онд Нью Йорк хотын судлаачид боловсролын хүртээмжийн талаарх судалгааг хийхэд СӨБ-д хамрагдаж чадахгүй байгаа хүүхдүүдийн нэг хэсэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болохыг илрүүлсэн байна. Монгол улсын хэмжээнд ч мөн адил боловсролын гадна үлдэж буй хэсэг бүлэг хүүхдүүдийн нэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгаа юм. 2024-2025 оны хичээлийн жил нийт 2150 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан байна. СӨБ-д хамрагдсан нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээс хамгийн өндөр хамрагдалттай байгаа нь аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдүүд байна. Үүнээс 4 болон 5 настай аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдүүдийн хамрагдалт их байна. Тэдний ялгаатай хэрэгцээ, онцлогт тохируулан дэмжлэг үзүүлэх нь чухал байна.

Түлхүүр үг: Сургуулийн өмнөх боловсрол, аутизмын хүрээний эмгэг, нийгэмшихүй, үнэлгээ, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө

Удирдагч: С.Батдулам, МУБИС

Суралцагчдын уншиж ойлгох чадварыг дэмжих арга зүй боловсруулан туршсан нь

Мөнхтөр Чойжамц*

Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Нийгэм, Хүмүүнлэгийн
ухааны сургууль, Түүхийн тэнхим
choijool72@gmail.com

Хураангуй. Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ-ОЕСД)-аас 1997 онд боловсролын салбарын Олон улсын үнэлгээний хөтөлбөрийг (PISA) санаачлан эхлүүлсэн. Энэхүү олон улсын үнэлгээ нь 15 настай сурагчдын унших чадвар, математик, байгалийн ухааны мэдлэг чадварыг үнэлэх, тэдний сургуулиас олж авсан мэдлэгээ бодит амьдралд хэрхэн ашиглаж буйг үнэлж, хэмждэг. Олон улсын PISA үнэлгээнд Монгол улс анх удаа 2022 онд хамрагдсан. PISA нь суурь боловсрол эзэмшсэн сурагчид танхимаар олж авсан мэдлэг, чадвараа амьдрал дээр хэрхэн хэрэглэж байгаа, тухайн улсын боловсролын тогтолцоо энэ чадварыг ямар хэмжээнд олгож байгааг тандан судалдаг сурлагын амжилтын олон улсын үнэлгээ юм. 2022 оны ПИСА-гийн судалгааны үр дүнгээс харахад Монгол суралцагчид унших чадварын сорилд хамгийн бага үнэлгээ авсан байна. ПИСА-гийн үнэлгээний тогтолцоонд унших чадварыг түвшингээр нь 1-ээс 6-р түвшинд үнэлж, түвшин бүрд онооны доод хязгаар тогтоосон байдаг. Жишээлбэл, 6-р түвшний доод оноо нь 698 бол 1-р түвшний хамгийн бага онооны дундаж нь 189 байна. Монгол сурагчдын унших чадварын дундаж оноо нь 378 байсан нь олон улсын дунджаас доогуур үзүүлэлтэй байв. Мөн гурван сурагчаас нэг нь л унших чадварын суурь түвшний мэдлэг, чадвартай байгаа нь тогтоогдсон юм. Монгол сурагчид нийт дүнгээрээ унших чадварын 2-р түвшинд үнэлэгдсэн байна. Энэ түвшний даалгаврууд нь сурагчаас тодорхой тэмдэг, санааг таньж мэдэх, дунд зэргийн эхийн ерөнхий зорилго болон тодорхой зорилтуудыг ойлгож, эргэцүүлэх чадвар шаардах шинжтэй. Сурагчид харьцуулах, богино, тодорхой, өгүүлэмжид тулгуурлан үндэслэлийн учир шалтгааныг тайлбарлах, үнэлэх, дүгнэх чадвартай байна. Иймд суралцагчдын уншиж ойлгох чадварыг дэмжих хэрэгцээ шаардлага байгааг харуулж байгаа бөгөөд энэхүү судалгааны ажилд суралцагчдын уншиж ойлгох чадварыг IX ангийн “Иргэний ёс зүйн боловсрол” хичээлд туршлаа. Иймд суралцагчдын унших чадварыг дэмжих зорилгоор иргэний ёс зүйн боловсролын хичээлд бүтээлчээр унших чадварыг төлөвшүүлэх аргуудыг туршсан. Энэ хүрээнд Бүтээлч уншлагын арга, Уншигчийн мэдрэмж төлөвшүүлэх арга, Эвлүүлгийн арга, Хамтран сурах аргуудыг судалж, тэдгээрээс Бүтээлч уншлагын арга болон Уншигчийн мэдрэмж төлөвшүүлэх аргыг сонгон авч туршилтын хичээлүүдийг зохион байгуулсан болно.

Түлхүүр үг: Унших, ойлгох, чадвар

Удирдагч: Ц.Баасандорж, МУБИС

**Багш мэргэжлээр суралцагчдын сэтгэл хөдлөлийн оюун ухаан,
стресс болон эмпати хоорондын хамаарал**

Тэрбиш Норовсүрэн**, Амарсайхан Ичинхорлоо*
Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсрол судлалын сургууль,
Боловсрол судлал, арга зүйн тэнхим
norovsuren@msue.edu.mn

Хураангуй. Сэтгэл хөдлөлийн өндөр чадамжтай, стрессийн түвшин бага, энэрэнгүй зан чанар сайтай багш нар сурагчдыг илүү үр дүнтэй дэмжих, харилцан ойлголцлыг бий болгох, амжилттай харилцаа тогтооход илүү сайн бэлтгэгдсэн байдаг. Гэсэн хэдий ч эдгээр хувьсагчдын хоорондын харилцан хамаарлыг төдийлөн нарийвчлан судалсан нь цөөн. Иймээс энэхүү судалгаа нь огтлолцол болон хамаарлын судалгааны дизайныг ашиглан эдгээр хувьсагчдын хоорондын хамаарлыг судалсан болно. Судалгаанд Сэтгэл Хөдлөлийн Оюуны Чадварын Асуулга (TEIQue), Стрессийн Мэдрэмжийн Хуваарь (PSS) болон Хүний Орлох Чадварын Индекс (IRI) бүхий асуулгыг ашигласан. Мэдээллийг багш мэргэжлээр суралцагч 4-р курсийн 46 оюутнаас санамсаргүй түүврийн аргаар цуглуулсан. Мэдээллийг дундаж болон стандарт хазайлт зэргээр тодорхойлох статистик шинжилгээ, Пирсоны хамаарал, олон хүчин зүйлт шугаман регрессийн шинжилгээг ашиглан боловсруулсан. Судалгааны статистикийн үр дүнд оролцогчид сэтгэл хөдлөлийн оюуны чадварын түвшин дунджаас дээш, стрессийн түвшин дунд, хүний орлох чадвар (энэрэнгүй байдал) дунд зэрэг байгааг харуулсан. Пирсоны хамаарлын шинжилгээ нь сэтгэл хөдлөлийн оюуны чадвар ба энэрэнгүй байдал хооронд эерэг хамааралтай, сэтгэл хөдлөлийн оюуны чадвар ба стресс хооронд дунд зэргийн сөрөг хамааралтай, стресс ба энэрэнгүй байдал хооронд сул сөрөг хамааралтай байгааг тогтоосон. Олон хүчин зүйлт шугаман регрессийн шинжилгээгээр сэтгэл хөдлөлийн оюуны чадвар болон стрессийн түвшин нь хамтдаа энэрэнгүй байдлыг статистикийн хувьд ач холбогдолтойгоор урьдчилан таамаглаж чадаж байгааг харуулсан. Эдгээр үр дүнгээс үзэхэд, сэтгэл хөдлөлийн оюуны чадвар өндөртэй төгсөх ангийн багш мэргэжлийн оюутнууд стресс багатай, энэрэнгүй чанар илүүтэй байх хандлагатай байна. Иймээс судалгааны үр дүнд тулгуурлан багш бэлтгэх хөтөлбөрүүдэд сэтгэл хөдлөлийн оюуны чадварыг хөгжүүлэх сургалт, стрессийг удирдах болон энэрэнгүй зан чанарыг төлөвшүүлэх семинар, үйл ажиллагааг тусгахыг зөвлөж байна.

Түлхүүр үг: Багш мэргэжлээр суралцагч, сэтгэл хөдлөлийн оюун ухаан, стресс, эмпати

**Дээд боловсролын багшийн дижитал чадамжийн асуудал
судалгааны онолын тойм**

Сурнаа (Liusurina)**

Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсрол Судлалын
Сургууль, Боловсрол судлал, арга зүйн тэнхим
surinaliu6@gmail.com

Хураангуй. Боловсролд шинэ дижитал хэрэгсэл, хөгжмийн программууд бүтээгдэн тасралтгүй өөрчлөгдөж байгаа нь багш нар хичээлийг илүү сонирхолтой, практикт үр нөлөөтэй болгохын тулд технологийн хэрэглээ, ур чадвар болон дижитал технологитой багшлахуй болон суралцахуйд суралцах, нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага тулгарч байна. Дижиталжсан анги танхимд багшлахад ямар мэдлэг, чадвар, хандлага шаардлагатай байгааг олж тогтоох, тодорхойлоход чиглэгдсэн баримт бичгүүд (ЕХ-ны боловсролын судалгааны төв, 2021; ЮНЕСКО, 2021; ЮНЕСКО, 2018; ISTE, 2023а гэх мэт)-ийг боловсруулж, хэрэгжүүлж буй нь "улс орнуудад багшийн дижитал чадамжийн талаар нэгдсэн ойлголт өгөх, дижитал чадамжийн үнэлэх, хөгжүүлэх бодлогыг

боловсруулах үндэс суурь" (Vuotikari et al., 2022, p.1) болж байгаа ч тусгай чадамж шаардлагатай мэргэжлийн багш нарт илүү нарийвчилсан байдлаар дижитал чадамжийг үнэлэх шалгуурыг боловсруулах нь зүйтэй. Тухайлбал, хөгжмийн сургалт нь сонголын, хөгжмийн зэмсгийн, найрал дуу, чуулгын дасгал зэрэг олон төрлийн мэдрэхүйн харилцан үйлчлэлийн үйл ажиллагааг агуулдгаараа онцлог тул мэргэжлийн тусгай чадамж дахь дижитал технологийн нарийн төвөгтэй байдлыг шийдвэрлэхийн тулд тусгайлан боловсруулсан дижитал чадамжийн хүрээ шаардлагатай.

Түлхүүр үг: Дижитал бичиг үсгийн мэдлэг, дижитал чадвар, дижитал чадамж, дижитал багшлахуй
Удирдагч: Б.Түмэнцэцэг, Р.Намжилдагва, МУБИС

Сурагчдын шүүн тунгаах чадварын үнэлгээ ба STEM хичээлээр хөгжүүлэх боломж

Төмөрбаатар Насантогтох**

Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсрол судлалын
сургууль, Боловсрол судлал, арга зүйн тэнхим
nasantogtokh.t@gmail.com

Хураангуй. Өнөө цагийн боловсролын зорилго нь зөвхөн мэдлэг эзэмшүүлэх бус, сурагчдын асуудал шийдвэрлэх, шүүн тунгаах, бүтээлчээр сэтгэх чадварыг хөгжүүлэхэд чиглэж байна. Сурагчдын шүүн тунгаах чадварыг STEAM сургалтаар дамжуулан хөгжүүлэх боломжийг эрэлхийлж, гарааны үнэлгээ тогтоох зорилгоор энэхүү судалгааг хийлээ. Тиймээс шүүн тунгаах чадварын үнэлгээний тест боловсруулж, ЕБСийн 6 дугаар ангийн 284 сурагчийг хамруулж, үр дүнд статистик шинжилгээ хийв. Судалгааны дүнгээс харахад: Өгөгдлийг уншаад ерөнхий утга санааг олох (дунджаар 0.70), дүгнэлт гаргах (0.66) зэрэг мэдээлэлд суурилсан чадварууд харьцангуй сайн байна. Өгөгдлийг уншаад уялдаа холбоо олох, (0.38), учир шалтгааныг тайлбарлах (0.53) зэрэг логик сэтгэлгээ шаардах даалгаврын гүйцэтгэл харьцангуй сул үзүүлэлттэй гарсан байна. Логик тооцоолол хийх (1.53), хувилбар тооцох (1.34) зэрэг олон хувилбартай шинжилгээ хийх чадвар нь дундаж харагдаж байна. Шийдвэр гаргах чадварын дундаж (0.98) байгаа нь сурагчид уялдаа холбоог олох, шалтгаан үр дагаврыг ойлгосны үр дүнд тодорхой шийдэл гаргахдаа ахиц байгааг харуулж байна. Судалгааны найдвартай байдлыг тодорхойлоход Cronbach's Alpha = 0.687 гарсан. Энэ нь анхан шатны, шинжлэх зорилготой судалгаанд хангалттай гэж үзсэнээр үнэлгээний хэрэгслийг шүүн тунгаах чадварыг хэмжихэд ашиглах боломжтой гэж дүгнэв. Эдгээр үр дүнг үндэслэн STEM хичээлээр шүүн тунгаах чадварыг хөгжүүлэх боломжийг судлав. STEM сургалт нь байгалийн шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик хосолсон, төсөлд суурилсан суралцахуйн арга зүй нь эргэцүүлэл, судлан шинжлэх, нээн илрүүлэх, хэрэглэх, харилцан суралцах зэрэг үе шатуудыг багтаадаг. Тиймээс STEM сургалт нь сурагчдыг логик дэс дараалалтай сэтгэх, туршилт хийх, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, шийдвэр гаргах зэрэг шүүн тунгаах чадваруудыг хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлнэ гэж үзэж байна. Тус судалгаа нь дунд ангийн түвшинд шүүн тунгаах чадварыг хөгжүүлэхэд STEAM боловсролыг үр дүнтэй ашиглах боломжийг эрэлхийлэх, цаашдын сургалтын хөтөлбөрт шингээх шаардлагыг дэвшүүлж байна.

Түлхүүр үг: Шүүн тунгаах чадвар, STEM боловсрол, 6-р анги, үнэлгээ, асуудалд суурилсан сургалт

Удирдагч: Д.Мөнхжаргал, Э.Мөнгөнтулга, МУБИС

Хиймэл оюун ухаан, түүний боловсрол дахь хэрэглээ

Түмэндэмбэрэл Тунгалагтамир**

Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсрол судлалын сургууль, Удирдлагын тэнхим
tunga979806@gmail.com

Хураангуй. Хиймэл оюун ухаан (Clancey, Intelligent Tutoring Systems: A Tutorial Survey, 1987) нь анхнаасаа л боловсролын салбарт хамааралтай байсан ч дэлхийн боловсролын тогтолцоонууд уламжлалт бүтцэдээ технологийн өөрчлөлтийг нэвтрүүлэхэд болгоомжтой ханддаг тул хөгжихөд нь олон бэрхшээл тулгарч ирсэн. Хиймэл оюун ухаан нь суралцах үйл явцыг хувь хүнд тохируулан чиглүүлэх багшийн системүүдийг бий болгох замаар боловсролыг өөрчлөн шинэчлэх амлалтыг өгч байсан. Энэхүү амлалт өнөөдөр биеллээ олж эхэлж байгаа бөгөөд орчин үеийн технологи дэлхийн өнцөг булан бүрд янз бүрийн загваруудыг туршиж эхэлсэн нь боловсролын салбарт олон шинэ асуултыг бий болгож байна (Unesco, 2019). Хиймэл оюун ухааны загваруудыг манай улсын боловсролын салбарт ч тодорхой хэмжээнд багш нар ашиглаж эхэлсэн бөгөөд энэхүү өгүүллээрээ “Багш нар хиймэл оюун ухааны үндсэн ойлголт, тухайлбал хиймэл оюун ухааны тодорхойлолт, хиймэл оюун ухааны загварууд хэрхэн суралцдаг талаарх суурь мэдлэг мөн тухайн хиймэл оюун ухааны хэрэгслүүд боловсролд хэрхэн тохирохыг шалгаж, баталгаажсан хиймэл оюуны хэрэгслийг ашиглах чадвартай байх ёстой (Unesco, AI competency framework for teachers, 2024)”-г үндэслэж хиймэл оюун ухааны онолын үзэл баримтлал, боловсрол дахь хэрэглээг тодорхойлохыг зорилоо. Хиймэл оюун ухаан, түүний боловсролын салбарт үзүүлэх нөлөө, хэрэглээний талаарх 2020 оноос хойш хийгдсэн эрдэмтдийн бүтээлүүдийг уншиж баримт бичгүүдийг харьцуулан, нэгтгэн дүгнэх замаар хиймэл оюун ухааныг боловсролд хэрэглэх онолын үндэслэл, практик чиг хандлага, өнөөгийн хэрэглээний боломжуудыг тодорхойлсон.

Түлхүүр үг: Хиймэл оюун ухаан, боловсрол, багш нар
Удирдагч: У.Амарзаяа, МУИС, Д.Цэдэвсүрэн, МУБИС

Уур амьсгалын өөрчлөлтийн бичиг үсгийн боловсролын судлагдсан байдлын тойм

Xiao Quansheng**

Монгол Улсын Боловсрол Их Сургууль, Боловсрол судлалын сургууль,
Боловсрол судлал арга зүйн тэнхим
864672911@qq.com

Хураангуй. Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн асуудал хурцдаж буй энэ үед уур амьсгалын өөрчлөлтийн бичиг үсгийн боловсрол нь энэхүү сорилтыг даван туулахад шаардлагатай гол чадваруудын нэг болж байна. Энэ судалгаа нь баримт бичгийн шинжилгээний аргыг ашиглан, уур амьсгалын өөрчлөлтийн бичиг үсгийн боловсролтой холбоотой шинжлэх ухааны нийтлэлийн хөгжлийн чиг хандлага, улс орнуудын хуваарилалт, агуулгын онцлогт дүн шинжилгээ хийх зорилготой. Судалгаанд Web of Science, CNKI, Google Scholar мэдээллийн сангууд дахь 2010-2024 оны хооронд нийтлэгдсэн уур амьсгалын өөрчлөлтийн бичиг үсгийн боловсролын талаарх эрдэм шинжилгээний өгүүллүүдийг судалж, одоогийн судалгааны дутагдал болон цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон болно.

Түлхүүр үг: Уур амьсгалын өөрчлөлт, бичиг үсгийн боловсрол, судалгааны тойм
Удирдагч: Н.Мөнхцэцэг, МУБИС

Түүхийн хичээлээр зураг зүйн мэдлэг, чадвар төлөвшүүлэх арга зүйн асуудалд

Одхүү Дашням*

Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Нийгэм Хүмүүнлэгийн

Ухааны Сургууль, Түүхийн тэнхим

dashnyam.info@gmail.com

Хураангуй. Зураг зүйн хэрэглэгдэхүүн бол түүхийн хичээлийн үндсэн хэрэглэгдэхүүн юм. Өнөө үед зураг зүйн хэрэглэгдэхүүн нь үзүүлэн таниулах уламжлалт хэрэглэгдэхүүн байхаас гадна сурагчдын танин мэдэх бие даасан үйл ажиллагааг хөгжүүлэх үндсэн хэрэглэгдэхүүн болоод байна. Түүхийн хичээл шинжлэн судлах буюу бүтээлчээр сурах арга барил эзэмшүүлэхэд өөрийн хувь нэмрийг оруулах ёстой бөгөөд үүний тулд судлагдахууны үндсэн чадваруудын тусламжтайгаар ийм чадвар эзэмшүүлэх боломжтой юм. Түүхийн хичээлээр эзэмшүүлэх үндсэн чадварын нэг бол зураг зүйн мэдлэг, чадвар юм. Шотландын судлаач Томас Карлейль “Он тоолол, газар зүй бол түүхийн сургалтын хоёр мэлмий” хэмээн хэлжээ. Манай түүхийн сургалтад газар зүйн зургийг тогтмол хэрэглэж ирсэн юм. Гэхдээ гол төлөв багшийн заах, танин мэдүүлэх үзүүлэн таниулах, хэрэглэгдэхүүн болгож ашиглаж ирсэн. Гэтэл өнөө үед манай боловсролын зорилго багш заах, сурагч идэвхгүй объект байхаас илүүтэй сурагч өөрөө мэдлэгээ бүтээх суралцахуйн идэвхтэй субъект байхыг шаардаж байна. Үүнийг дагаад хэрэглэгдэхүүн түүний зориулалтыг өөрчлөх шаардлага бий болоод байна.

Түлхүүр үг: Зураг зүйн мэдлэг, чадвар, зураг зүйн хэрэглэгдэхүүн, газар зүйн зураг

Удирдагч: Х.Баярмаа, МУБИС

Суралцагчдын өөрийн удирдлагатай суралцахуйг интеграцид суурилсан даалгавраар дэмжих нь

Давааням Аззаяа*

Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсрол судлалын сургууль,

Боловсрол судлал арга зүйн тэнхим

azzayadawaanyam@gmail.com

Хураангуй. Мэдээлэл харилцаа холбооны технологийн хурдацтай хөгжил, дижитал шилжилттэй холбоотойгоор боловсролын тогтолцоо, сургалтын хэлбэр, суралцах арга барилд ихээхэн өөрчлөлт гарч, интернэт, цахим платформд суурилсан суралцахуйг зохион байгуулах боллоо. Иймд суралцагчдыг интеграцид суурилсан цахим даалгавраар өөрийн удирдлагатай суралцахуйг дэмжиж, сурлагын амжилтыг сайжруулах туршилтыг (Garrison, 2000) боловсруулсан SRL-(Col) Community of Inquiry загвараар туршилт, судалгааны үр дүнг тооцсон. Суралцагчдын өөрийн удирдлагатай суралцах үзүүлэлтийг Т-Тест шалгахад хоорондоо статистик ач холбогдолтой ялгаатай гарсан бөгөөд 4.8% ахисан үзүүлэлттэй. Харин сурлагын амжилтын үр дүнг Т-Тест шалгаж үзэхэд ялгаатай буюу статистик ач холбогдолтой 26.4%-аар өссөн. Мөн өөрийн удирдлагатай суралцахуйн 4 үе шат бүрийн хамааралд корреляцийн шинжилгээ хийж үзэхэд туршилтын өмнөх ба дараах сурлагын амжилттай шууд хүчтэй хамааралтай байна. Иймээс туршилт судалгааны үр дүнгийн үзүүлэлт, өгөгдлийн шинжилгээнээс харахад холбогдолтой байна.

Түлхүүр үг: Өөрийн удирдлагатай суралцахуй, интеграцид суурилсан цахим даалгавар, сурлагын амжилт

Удирдагч: Г.Баярмаа, МУБИС

Азийн зарим улсын уламжлалт гар сүлжмэл урлалыг харьцуулсан судалгаа

Чулуунбаатар Батцэцэг**

Монгол Улсын Боловсрол Их Сургууль, Боловсрол судлалын сургууль,

Боловсрол судлал, арга зүйн тэнхим

ch_battsetseg@msue.edu.mn

Хураангуй. Япон, Солонгосын уламжлалт гар сүлжмэлийг Монголын зоос ширээний сүлжмэлтэй харьцуулж, онцлог ялгаа, адил төсөөтэй талуудыг тодруулахыг зорилоо. Япон, Солонгос орнуудын уламжлалт гар сүлжмэлийн үүсэл хөгжил, сүлжих аргачлал, гар урлалын тоног төхөөрөмж, үйлдвэрлэгдсэн сүлжмэлийн хэв маяг, эд эдлэлд туссан амь амьдрал ахуйн өвөрмөц онцлог, чимэглэлийн аргыг судалсан болно. Эдгээр орнуудын гар сүлжмэлийг судлахдаа түүхэн эх сурвалж, ном сурах бичиг, судалгаа шинжилгээний бүтээл, видео, баримт бичлэгт харьцуулалт хийх, задлан шинжлэх нэгтгэн дүгнэх аргыг ашиглалаа. Япон, Солонгос, Монголын уламжлалт гар сүлжмэлүүд нь утас ороож бэлтгэх, бөхөлж тогтоох, сүлжмэлийн хэлбэр, өнгө, хээ, утасны давтамж, хоёр гараар ээлжлэн тэгш хэмтэй сүлжих арга, зориулалт, чимэглэл, ширээ нь дугуй хэлбэртэй байдгаараа ижил төстэй талууд бий боловч эдгээр сүлжмэлүүд нь өөр өөрийн гэсэн онцлог ялгаатай байна. Жишээлбэл, Зоос ширээний сүлжмэл нь 4 утсаар бөөрөнхий сүлжихдээ нэг орхиулд хэдэн ч утсыг давхарлан ороож сүлжиж болдог. Хавтгай сүлжихдээ 4-өөс дээш 64 хүртэлх утсаар, нэг орхиулд нэг л утсыг ороож сүлжилтийг хийдэг. Сүлжмэлийг чангалах, эдлэл чимэглэх, ширээний гадаад бүтэц, сүлжмэлийн үүсэх хэлбэр нь бөөрөнхий хавтгайгаас гадна долгионтой мэт харагдахаар сүлжигддэгээрээ бусад хоёр орны сүлжмэлээс ялгаатай. Японы гар сүлжмэлийг ерөнхийд нь Кумихимо гэж нэрлэдэг бөгөөд энэ сүлжмэл нь дотроо Марудай, Аятакейдай, Такадай, Каракумидай, Какудай гэсэн олон төрөлтэй. 2-100 хүртэл утсаар сүлждэг ба хоёрын тооны давтамжаар сүлждэг, нэг дамарт олон утсыг ороож бэлтгэдэг, сүлжмэлийг тусгай зориулалтын модоор цохиж чангалдаг, сүлжээд бэлэн бүтээгдэхүүн болгон хэрэглэдгээрээ ялгаатай. Солонгос улсын уламжлалт гар сүлжмэлийг тусгай зориулалтын ширээн дээр сүлждэг, бэлэн бүтээгдэхүүн тэлээ, бүс, бугуйвч, хүзүүний зүүлт гэх мэт зүйлүүдийг сүлждэг. Бүдүүн нарийн төрөл бүрийн нарийн бүдүүн утсыг хэрэглэдгээр онцлогтой. Ийнхүү монгол үндэсний уламжлалт зоос ширээтэй адил болон төсөөтэй, онцлог ялгаатай гар сүлжмэл Азийн зарим улс оронд хэрхэн хөгжиж байгааг энэ удаагийн өгүүлэлдээ харьцуулан авч үзлээ.

Түлхүүр үг: Монгол, Япон, Солонгосын уламжлалт гар сүлжмэлийн харьцуулалт, онцлог ялгаа, төсөөтэй тал, зоос ширээний сүлжмэл

Удирдагч: Д.Сэрээтэрдорж, МУБИС

“Эрдэнийн сан Субашид”-ийн сурган хүмүүжүүлэх үзэл санааны судалгаа

Gegentana**

Монгол Улсын Боловсрол Их Сургууль, Боловсрол судлалын сургууль,

Боловсрол судлал, арга зүйн тэнхим

g976254904@163.com

Хураангуй. "Субашид"-ыг бүтэн нэрээр "Сайн номлолт эрдэнийн сан" хэмээдэг. Санскритаар "Subhāṣitaratnanidhi nama śāstra", төвдөөр "Legs par bshad pa rin po che'i gter shes bya ba'i stan bcos" гэх бөгөөд монголчууд "Сайн номлол" хэмээх утгатай "Субашид" гэх товч санскрит нэрээр нь нэрлэсээр ирсэн билээ. ХIY зууны үеийн тарнич тойн Сономгара-гийн орчуулга одоо мэдэгдэж буйгаар хамгийн эртнийхэд тооцогдох билээ. Түүний дараа ХYI зууны үед Ойрадын Зая бандида Намхайжамц тод үсгээр, ХYII-ХYIII зууны үед Сөнөд хошууны хэлмэрч эрдэмтэн Данзанчойдор,

ХҮШ зууны үед Урад хошууны Мэргэн гэгээн хэмээн алдаршсан Лувсамдамбийжалцан, Цахар гэвш Лувсанчүлтэм нар орчуулснаас гадна XIX зууны үед Буриадын эрдэмтэн Дана-гийн гэгээн буюу Төгөлдөрийн Галсанжинба бээр Мэргэн гэгээний орчуулгыг хянан найруулсан бөгөөд мөн XIX зууны сүүлээр Буриадын эрдэмтэн Номтын Ринчэн буюу Сумадираднаа мөн хоёр удаа орчуулжээ. Эрдэмтэн мэргэд "Субашид"-ын эх зохиолыг уншиж танилцан, товч дэлгэрэнгүй тайлбаруудыг төвд, монгол хэлээр зохиосны сацуу гадаад, дотоодын судлаач нар хэрхэн судалж, орчуулсан талаар тоймлон өгүүлье.

Түлхүүр үг: Субашид, сурган хүмүүжил, үзэл баримтлал
Удирдагч: Чү.Байгалмаа, МУБИС, О.Дэмчигмаа

Case studies of the professional development of efl teachers context the self as source

Cha Na**

Department of Educational Studies Methodology, School of Educational Studies,
Mongolian National University of Education
619652689@qq.com

Abstract. As one of the most important carriers of information in the international community, English has penetrated into all fields of social life and has become a significant strategy for national educational development and international exchanges. Consequently, professional development of EFL teachers is becoming a fundamental theme in foreign language educational researches. On a basis of a literature review of the teachers' professional development in a general sense, in terms of EFL field, and on taking the self as source, the research reports the unsatisfactory aspects in the present researches on professional development of EFL teacher in China, specifically speaking, the current researches are, in most cases, short-term narrative stories from perspective of teachers or qualitative analysis from perspectives of the teacher researchers instead of the teachers concerned, and lacking in due attention to theorization of teacher professional development. A new form of teachers' professional development with its definition, connotation, features and model is accordingly proposed. According to the researcher, there is a hierarchy in the classification of the concept of *the self as source*, that is to say, firstly, awareness of autonomous professional development of the teachers; secondly, practices of investigating and exploring into as well as researching and reflecting on their teaching, scientific researching and teacher emotion; thirdly, spiral action research including self-plan, self-implementation, self-adjustment, self-reflection and self-evaluation by the teachers themselves to improve their own professional development. A single-case study focusing on the three-year action research on the researcher's professional development with the self, a multiple-case study including within-case and cross-case analysis and responses from a large-sample questionnaire filled by EFL teachers at a tertiary level are presented to address the following three research questions:

1. To what extent is the researchers' action research on her own professional development with the self as source effective? What changes and influences does such a research bring to her professional beliefs, professional knowledge, professional competency, professional emotion and awareness for autonomous professional development? What changes and influences does such a research bring to the improvement of her students' study and other aspects and to the educational institute and professional community where she works and joins?
2. In a general sense, what are the core elements of professional development of EFL teachers with the self as source?

3. With the presupposition that the EFL teachers are all engaged in practices of teaching, researching, learning, reflection and cooperation, in what way do the three levels of the self as source enhance the effectiveness of their professional development?

As the first nine-year empirical study on EFL teachers' professional development with the self as source, this research stands itself out for its application of SPSS 28.0 to the analysis of the quantitative data and of Nvivo 14.0, the updated tool in the international research circle, to the analysis of qualitative data, as well as some analysis methods in case study method such as recapitulation sheet and matrix charts. After an in-depth analysis of the professional development materials of the researcher, of two teacher researchers, Professor Nunan and Ms. Zhong, of a brief analysis of the professional development materials of six distinguished experts in EFL circle and of the narrative responses from questionnaires filled out by a large number of EFL teachers at a tertiary level in Shanghai and six provinces, it is found that the researcher's professional development is feasible and effective for her, and that teaching, researching, learning, reflection and cooperation are the core elements for EFL teachers in terms of their professional development and that, supposing that the teachers have already engaged in the teaching, researching, learning, reflection and cooperation activities, all of the three levels of *the self as source* can improve the professional development of individual EFL teacher in a progressive way, the more resemblance their professional development bears to action research, the more desirable and satisfactory their professional development might be, and the professional development with the self as source based on the self-directed action researches is believed to be the most effective. Theoretically and technically speaking, the research presents a comprehensive literature review of the EFL teachers' professional development with the self as resource, definitions and explanations of the original key terms and to collect and analyse the data with various research methods and advanced research tools. Practically speaking, the research presents a longitudinal research lasting more than nine years and a bottom-up empirical study from single-case study to multiple-case study and then to a large-sample questionnaire, leading to an increasingly higher empiricism and generalization. Despite the problems that the mainly qualitative research with research methods of case study, and narrative inquiry is predestined to be criticized by its subjectivity, that the research methods are not skillfully and effectively handled and that there is not sufficient attention to the external influencing factors or relevant evaluation of some of the researches reviewed, this research is expected to serve as a constructive theoretical and empirical exploration of and reference for the professional development with the self as source for the EFL teachers who are eager to promote their professional development, aiming to encourage and help these teachers to conduct their professional development research through teaching, researching, learning, reflection and cooperation and gradually establish more professional development communities. In this case, the current professional development and the quality of EFL teachers and the EFL education will be improved, contributing to make our country more powerful.

Keywords: Teachers' professional development, EFL teachers, the self as source, case studies

Удирдагч: Ч.Байгалмаа, МУБИС

Хятад хэлний бичих дадал хичээлд сургалтын зарим аргыг хэрэглэж туршсан үр дүн
(МУИС-ийн ББС-ийн хятад хэлний орчуулагч мэргэжлийн ангийн жишээгээр)

Төмөрбаатар Энэбиш**

Монгол Улсын Боловсрол Их Сургууль, Боловсрол судлалын сургууль,

Боловсрол судлал, арга зүйн тэнхим

t.enebish999@gmail.com

Хураангуй: Хөдөө нутагт хятад хэл сурах орчин хязгаарлагдмал, сүүлийн үеийн шинэлэг заах арга барил, орчин үеийн технологи хомсхон байна. Үүний үр дүнд суралцагчдын хэрэгцээнд тохирсон

үр дүнтэй хятад хэлний хичээл зохион байгуулж, хятад хэл дээр бичих чадварыг нь дээшлүүлэх шаардлагатай байна. Ялангуяа боловсролын өнөөгийн шинэчлэлийн хүрээнд суралцагч дээр төвлөрсөн, мэдлэг бий болгоход суурилсан заах арга барил нь суралцагчдын хамтын бүтээлч байдлыг хөгжүүлэх, бичих чадварыг дээшлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Энэ өгүүлэлд идэвхтэй суралцах аргаар хятад хэлний суралцагчдын бичих чадварыг сайжруулах боломжуудыг авч үзэн, энэ сэдвээр хийсэн практик туршилтын үр дүнг танилцуулав.

Түлхүүр үг: Бичих чадвар, хятад хэл, суралцагчид

Удирдагч: Г.Цогзолмаа, МУБИС

Бага ангийн багш нар сурагчдын өдрийн тэмдэглэлийг уншихтай холбоотой зөрчлийн судалгаа

Zhang Mingzhi**

Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсрол судлалын сургууль,
Боловсрол судлал, арга зүйн тэнхим

2283036246@qq.com

Хураангуй. Судалгааны асуудлаа олж авахын тулд Түнлио хотын Бао Лон шан бага сургуулийн 215 багшаас ёс зүйн чиглэлийн судалгаа авсан. Үүнд 24-35 насны багш нар хамрагдсан. Асуулга нь 8 асуулттай байсан, эдгээр асуулт дотор 7-р асуулт “Түнлио хотын бага ангийн багш нар сурагчдын өдрийн тэмдэглэлийг зөвшөөрөлгүйгээр авч унших нь сурагчид ямар сөрөг үр дагавартай вэ?” гэсэн асуултын хариултууд анхаарал татсан учир үүнийг цааш гүнзгийрүүлэн судлахаар болсон. Үүнд:

Бага ангийн сурагчдын хөтлөх өдрийн тэмдэглэлд:

1. Сурахуйн өдрийн тэмдэглэл, 2. Хувийн тэмдэглэл гэсэн хоёр янз байх нь оновчтой.

1/ Сурахуйтай холбоотой өдрийн тэмдэглэлийг багш нар уншиж болох бол дараагийн хувийн тэмдэглэлийг багш авч уншиж болохгүй.

2/ Сурагчид өдрийн тэмдэглэл яагаад хөтлөх талаар тодорхой заавар, зөвлөгөө зэргийг багш нар өгдөг байх нь зүйтэй.

3/ Өдрийн тэмдэглэлийн талаар багш сурагчдын ойлголтын зөрүүг арилгах тал дээр тодорхой зүйл хийх шаардлага өндөр байна.

4/ Сурагчдын хөтлөх өдрийн тэмдэглэл нь албадлагын бус, илүү уян хатан байх цаг болсон байна.

Түлхүүр үг: Бага ангийн багш нар, бага ангийн сурагчид, өдрийн тэмдэглэл

Удирдагч: Д.Мөнхжаргал, МУБИС

НИЙГЭМ, ХҮМҮҮНЛЭГ

**Мөнх хааны гэрэлт хөшөөний бичээсний зохиомж, уран сайхны
шийдэлд хийсэн ажиглалт**

Батаа Балжин**

Монгол Улсын Боловсрол Их Сургууль, Дүрслэх урлаг,
Технологийн сургууль, Дизайн зураг зүйн тэнхим
baljin.b@ulaanbaatar.edu.mn

Хураангуй. Монголчуудын өвөг дээдсийн бүтээсэн гэрэлт хөшөө, чулуу, хана туурган дээрх бичээснүүд нь монголчуудын төдийгүй дэлхийн түүхийг агуулсан хэл шинжлэл, соёл, урлагийн үндэсний үнэт өв юм. Энэ нь хүн төрөлхтний нийгэм, соёл, урлагийн ертөнцөд өөрийн өвөрмөц хэв маяг бүхий төрх, уран сайхан зурлага, тиг, зохиомжоороо ялгардаг. Энэ ялгарч буй төрх байдал нь дээрээс доош босоо чиглэлд бичдэг уламжлалт хэв маягт оршиж байна. Хаадын зарлиг, гэрэлт хөшөө болон бусад төрөл бүрийн бичээсийг чулуу, хана туурганд дээр сийлж үндэсний хэв маяг, дүр төрхийг бүрдүүлсэн нь уран сайхны үнэ цэнтэй байдлыг илтгэж байна. Мөнх хааны гэрэлт хөшөө бол монгол нутгаас олдсон, XIII зууны бичиг үсгийн хөгжлийг харуулсан, чулууны бичээсийг төлөөлөх чухал дурсгалын нэг бөгөөд хааны сүр хүчийг илэрхийлсэн, монгол бичгийн өвөрмөц уран бичлэгийн уламжлалыг агуулсан, бичээснүүдийг зохиомжилсон хэлбэр, уран сайхны шийдлээрээ онцгой эх сурвалж юм. Хэмжээний ялгаатай хэсгүүдээр бичээсний магнайн гарчиг, монгол болон хятад бичээс гурван хэсэгт бүлэглэсэн, зохиомжийн харагдах байдлыг сайжруулж, уншигчийг бичээсний ач холбогдлын дарааллаар удирдан чиглүүлж байгаа нь мөр хоорондын орон зайг харьцаат байдлаар шийдвэрлэсэнд оршиж байна. Мөнх хааны гэрэлт хөшөөний бичээсийг зохиомжлохдоо тэгш хэмгүй тэнцвэрт бус байдлыг хоосон орон зайгаар тэнцвэрийг хангасан, мөр болон үсэг хоорондын зайгаар хэмнэлтэй, хэмжээний болон зэрэгцүүлэлтийн зарчмыг ашиглаж харааны дараалал болон ялгарлыг бий болгосон уран бичлэгийн бүтээл юм.

Түлхүүр үг: Монгол бичиг, уран бичлэг, хэв маяг, тиг, харьцаа, үсгийн урлаг
Удирдагч: Р.Гоцбаяр, МУБИС, Б.Даваасүрэн, МУИС

Үндэсний сурын “нээлтийн харваа” тэмцээний амжилтад хийсэн

Энхбаяр Баатарсүрэн**

Монгол Улсын Боловсрол Их Сургууль, Боловсрол судлалын сургууль,
Боловсрол судлал, арга зүйн тэнхим
Baatarsuren@msue.edu.mn

Хураангуй. Үндэсний сурын харваа нь зөвхөн спортын өрсөлдөөнөөс гадна Монголын ард түмний түүх, соёл, боловсролын үнэт өвийг хадгалан түгээх, үеэс үед уламжлуулах биет бус соёлын өвийн нэгэн чухал хэсэг билээ. Сүүлийн жилүүдэд энэхүү спортын хүрээнд сонирхон оролцогчдын тоо нэмэгдэж, хөгжлийн хандлага өргөжин, харваачдын ур чадварын түвшин ч ахиж байна. Энэ судалгаагаар Монголын Үндэсний Сурын Холбооноос жил бүр зохион байгуулдаг “Нээлтийн харваа” улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцсон харваачдын тоо, чанарын үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж, 2023 ба 2024 оны үзүүлэлтүүдийг харьцуулсан тоон ба чанарын судалгаа хийсэн болно. Судалгааны үндсэн зорилго нь оролцогчдын амжилтын түвшин, тэдний ангилал, хүйс, насны бүлэг, бай, хана, хасаа байны оноо, мөн нийт сумны гүйцэтгэл зэрэг шалгуураар дасгал сургуулилт, оролцооны өсөлт, чанарын ахиц зэрэгт үнэлгээ хийхэд оршино.

Үүнээс гадна, сурын харвааны тэмцээнүүдийн дүнг ерөнхийд нь нийт сумны нийлбэр оноогоор байр эзлүүлэн үнэлдэг бөгөөд энэ нь тамирчдын ур чадварыг илэрхийлэх нэгэн чухал шалгуур үзүүлэлт болдог. Тиймээс энэхүү судалгаа нь ирээдүйн сургалтын хөтөлбөрийг төлөвлөх, дэмжлэг үзүүлэх бодлогын үндэслэл болох ач холбогдолтой юм.

Түлхүүр үг: Сумын харваа, үндэсний спорт, харваачдын ангилал, статистик шинжилгээ

Өс хонзонгийн дүрслэл ба Жангар тууль

Сумъяасүрэн Батзориг**
Монгол Улсын Боловсрол Их Сургууль, Нийгэм, хүмүүнлэгийн
ухааны сургууль, Утга зохиолын тэнхим
sumiyasurenbatzorig@gmail.com

Хураангуй. Өрнө, дорнын уран зохиолд эртнээс өс хонзонгийн сэдэв үлэмж томоохон байр суурь эзэлдэг. Эртний Грек, Ромын домог туульсаас өгсүүлээд У.Шекспирийн эмгэнэлт жүжгүүдэд, романтизмын үеийн уран зохиол, саяхны Ф.Достоевский хүртэл энэхүү сэдвийг даруй хөндөж, зохиомжийнхоо гол төвд байрлуулж ирсэн бөгөөд зарим судлаачдын үзэж буйгаар бол өс хонзон нь уран зохиолын “мөнхийн сэдэв” гэж ч үзэгдэх боломжтой даяар түгээмэл сэдэв ажээ. Манай уран зохиолч энэ зүй жамаас холдох боломжгүй юм. Тиймийн тул Жангар тууль, баатарлаг тууль болохын хувьд үйл явдал дайн тулаанд төвлөрч, эхнээс төгсгөл хүртэлх өгүүлэгдэхүүний бүтцийг дайтахын шалтгаан болон үр дүнгийн уялдаа холбоонд суурилан өгүүлдэг. Туульд хайртай морийг нь булаана гэхэд, хатныг нь булаана гэхэд, эрх мэдлийн төлөө, нутаг харьяатын төлөө, нэр хүндийн төлөө гэх мэтээр янз бүрийн үүдэл, нөхцөлөөс шалтгаалан дайн тулаанд хүрэх авчиг тэдгээрийг харьцуулан үзвээс шалтгааны шалтгаан гэж хэлж болмоор сэдэв байгаа нь “өс хонзон” хэмээх ойлголтод нэгдэж байгаа төдийгүй уг туульд өс хонзон үйл явдлын зангилаа болж, үйл явдал цаашид өрнөх болзлыг хангадаг гэж болно. Бид энэхүү өгүүллээрээ Жангар тууль дахь өс хонзонгийн дүрслэлийг олдворлож, энэ дүрслэл нь туулийн явдалд ямар хувь нэмэр оруулж байгаа тухайд тодруулахыг хичээлээ.

Түлхүүр үг: Өс хонзон, ёс суртахуун, ургийн нэр төр, домог зүйн зохиомж, тэмцлийн шалтгаан
Удирдагч: Г.Батсуурь, МУБИС

Хөгжмийн мэргэжлийн суралцагчдад тулгамдаж буй зарим асуудал (хийл хөгжмийн жишээн дээр)

Энх-Амгалан Энхцэцэг**
Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсрол судлалын сургууль,
Боловсрол судлал арга зүйн тэнхим
tseegiihbk@gmail.com

Хураангуй. Энэхүү судалгааны зорилго нь Монгол улсын мэргэжлийн хөгжмийн сургуульд суралцаж буй чавхдаст хөгжмийн суралцагчдад тулгарч буй асуудлуудыг шинжлэх явдал юм. Судалгаанд нийт 35 оролцогч хамрагдаж, 10 төрлийн эрсдэлт хүчин зүйлийг тодорхойлсон. Эдгээр эрсдэлүүдийг гэр бүлээс хамаарах хүчин зүйлс, бие махбодын хөгжлийн өөрчлөлт, нийгмийн харилцаатай холбоотой асуудлууд гэсэн гурван бүлэгт ангилсан. Онцлох зүйл нь булчингийн

тогтолцооны гэмтэл авах эрсдэл сурагчдын дунд өндөр байгааг тогтоосон. Цаашид багш, сурагчдад зориулсан сургалтын хөтөлбөр, сургалтуудыг боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай. Судалгаанаас үзэхэд мэргэжлийн хөгжмийн боловсрол эзэмшиж буй сурагчдын булчин, үе мөчний гэмтлээс урьдчилан сэргийлэх шинэ арга зүйг боловсруулах зайлшгүй хэрэгцээ байгааг баталж байна.

Түлхүүр үг: Мэргэжлийн хөгжмийн сургалт, булчингийн тогтолцооны эмгэг, урьдчилан сэргийлэлт, эрсдэлт хүчин зүйл
Удирдагч: Н.Мөнхцэцэг, МУБИС

Дөчин дөрвөн хоёрын их цаазын судалгааны уламжлал шинэчлэлийн асуудалд

Ганхуяг Эрхэмбаяр**
Монгол Улсын Боловсрол Их Сургууль, Нийгэм, хүмүүнлэгийн
ухааны сургууль, Түүхийн тэнхим
erkhmee.glu@gmail.com

Хураангуй. Дөчин дөрвөн хоёрын “Их цааз” судалгаа нь XVII зууны Төв Азийн улс төрийн байдал, Халх Ойрадын харилцаа, монголчуудын нийгмийн байгуулал, хууль цааз, шашин соёл, хэл шинжлэл болон тусгаар тогтнолын түүхийн судалгаанд томоохон байр суурь эзэлдэг. Өөрөөр хэлбэл энэ сурвалж хууль цаазын бусад эх сурвалжуудаасаа хамгийн эхэнд буюу 1724 онд Оросын гадаад яамны коллегийн нарийн бичгийн дарга В.М.Бакунин орчуулж, судалгааны эргэлтэд орсноороо онцлогтой юм. Харин монголын түүхчдээс “Их цааз”-ын талаарх судалгааг XVIII зууны дунд үеэс эхлэн хийж, Раднаабдраагийн “Равжамба Зая бандидын тууж сарны гэрэл”, “Халимаг хаадын тууж”, “Хөх нуурын чуулганы цаазын бичиг”, Гаваншаравын “Дөрвөн Ойрадын түүх” зэрэг зохиолуудад 1640 оны 09 сарын 20-ны Халх Ойрадын чуулганд ирсэн ноёд лам нарын уг гарвал, тэдний түүхэн үйл ажиллагаа, хууль цаазын утга холбогдол, мөн чанар зэргийг хөндөн өгүүлсэн байдаг. Тэгвэл бид энэхүү илтгэлдээ судалгааны уламжлалын нэгтгэж, гадаад дотоодод хэвлэгдсэн судалгааны бүтээлийн ерөнхий тойм байдлыг хийж, сүүлийн үеийн шинэ үр дүн, арга зүйн зарим асуудлыг дэвшүүлэхийг зорьсон. “Их цааз судлал” гэсэн бие даасан салбар судлал болон хөгжиж, Монгол Улс төдийгүй АНУ, ОХУ, Япон, ХБНГУ, БНХАУ зэрэг орны эрдэмтэн, судлаачдын судалгааны нэг чиглэл болж хөгжсөн байна. Тэгэхдээ судлаачид нэг, Эх сурвалжийн талаас (сурвалж судлал) хоёр, Хууль цаазын талаас гурав, Хэл шинжлэлийн талаас дөрөв, Түүх, соёлын талаас нь тус тус судалжээ. Цаашид Их цаазын судалгааны шинээр дэвшигдэж буй онол арга зүйн шинэчлэлүүд түүнийг дагасан ойлголт, нэр томъёоны талаарх саналууд нь өмнөх судалгааны үр дүнгүүдийг эргэн харахад хүргэж байна. Ямартай ч хамгийн чухал нь Их цаазын хамгийн баталгаатай эхийг олох бөгөөд бид энэ талын харьцуулсан судалгааг хийж E83 эхийг онцлон хамгийн найдвартай эх гэж үзэж байна.

Түлрүүр үг: Хууль цааз, судалгааны шинэ хандлага, төр улс, аймаг
Удирдагч: На.Сүхбаатар, МУБИС, Г.Алтансүх

Мөнгөний дарханы чадварын судалгаа

Jun Xi**

Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсрол судлалын сургууль,
Боловсрол судлал, арга зүйн тэнхим
Junxi88366034@gmail.com

Хураангуй. Дэлхий үнэт эдлэлийн соёлын чухал бүрэлдэхүүн хэсэг болох үнэт эдлэл нь, нүүдэлчин ард түмний амьдралын хэв маяг, түүх соёл, урлагийн үзэл баримтлалын цогц тусгал болох юм. Үндэсний гоёл чимэглэлийн урлаг нь үндэстний соёлын чухал бүрэлдэхүүн хэсэг билээ. Нүүдэлчин үндэстний гоёл чимэглэлийн урлаг нь түүний түүхий эд материал, өвөрмөц гар урлал, соёлын утга агуулга зэрэг нь умард нутгийн нүүдэлчин ард түмний дүр төрхийг шингээсэн онцлогтой. Энэхүү сэдвийн хүрээнд олон салбарын судалгаа хийгдсээр ирсэн бөгөөд гоёл чимэглэл, ялангуяа мөнгөн эдлэлийн түүхэн хөгжлийн ул мөр, хэв маягийн хувьсал, хийцийн хөгжлийн талаар нарийн судалгаанууд мөн хийгдсээр иржээ. Мөнгөн дарханы уламжлалт соёлын утга агуулгааг монголын түүх соёлтой уялдуулан тухайн мэргэжлээр суралцаж буй залуучууд, оюутанд таниулах хэрэгцээ шаардлага тулгамдсаар байна. Залуучуудын хувьд гар урлал, соёлын шинэ утга санаагаар дамжуулан өв уламжлал, түүх соёлоо танин мэдэх, түүнийгээ хойч үедээ өвлүүлэн үлдээх, ур ухааныг бий болгох чухал юм. Энэ нь гоо зүйн боловсролын чухал илэрхийлэл, соёлын олон янзын тод жишээ болсоор байна. Түүхээс харахад уламжлалт гар урлал нь хүмүүсийн амьдралын хэв маяг, үнэт зүйлсийн тусгал болж улмаар амьдралын зайлшгүй чухал хэсэг байсаар ирсэн аж. Орчин үед уламжлалт гар урлалын мэдлэг, ойлголттой хүмүүс бага болж үйлдвэрлэлийн аргаар гоёл чимэглэлийг хийж хэрэглэх болсон тул хүмүүсийн хэрэгцээнд тулгуурлан уламжлалт гар урлалын үнэ цэнийг илрүүлэх, улам боловсронгуй болгох, хөгжүүлэх, дэлгэрүүлэх шаардлага тулгарч байна. Цаг үе солигдохын хэрээр уламжлалт гар урлалд тулгарч буй хүндрэлүүд улам тодрон гарсаар байна. Иймд уламжлалт ур ухаанаа өвлүүлэн хөгжүүлэхийн тулд урчууд эерэг хандлагатай байж, хойч үеэ сургаж бэлдэх нь чухал юм. Үүний тулд их сургуулиудад орж буй дарханы хичээлийг чанаржуулах, оюутны сонирхлыг нэмэгдүүлэхэд түлхүү анхаарах цаг нь болсон байна. Монголын алт, мөнгөн эдлэлийн талаарх судалгааны бүтээлүүдээс үзвэл алт, мөнгөн эдлэлийн гоо зүй, соёл, эдийн засаг, түүх болон нутаг нутгийн онцлог шинж, урлах арга ухаан, үйлдвэрлэлийн технологи зэргийг түлхүү судлан үзсэн байдаг. Тухайлбал Д.Энхдаваа, Л.Батчулуун нарын бүтээлүүдийг дурдаж болно. Харин алт, мөнгөн эдлэлийн соёлын илэрхийлэл, орчин үеийн хөгжил, өнөөгийн байдал, мөнгөн дархны урлах арга ухааныг заах, ур чадвар, биет бус өвийг өвлүүлэх, уламжлуулахын хүрээнд авч үзсэн судалгаа цөөхөн байна. Энэхүү судалгаагаар уламжлалт урлахуйн ухааныг орчин үеийн боловсролд үр ашигтай, Уламжлалт урлагийн боловсрол нь олон талт-түүх, соёл, техник, бүтээлч сэтгэлгээ-мэдлэг чадварыг цогцоор хөгжүүлдэг үйл явц мөн. Гар урлалын уламжлалт өвийг залгамжлах хүний нөөцийн чанар дээшилдэг. өргөн утгаараа соёлын тогтвортой хөгжил, боловсрол, шинжлэх ухаан, соёлын бодлогын огтлолцолд үнэ цэнтэй мэдээлэл, санаа өгч байна. Цаашид энэхүү судалгааг гүнзгийрүүлэн хөгжүүлж, уламжлалт урлагийн боловсролын талаар илүү өргөн хүрээний судалгаа (жишээлбэл, олон улсын харьцуулсан судалгаа, өөр урлагийн төрөл дээрх туршилтууд) хийх нь зүйтэй байна. Энэ нь Монголын болон бусад үндэстний соёлын өвийг сэргээн дэлгэрүүлэх, залуу үедээ өвлүүлэх үйлсэд шинжлэх ухааны үндэслэлтэй шийдлүүдийг гаргаж өгөх ач холбогдолтой бүтээл боллоо.

Түлхүүр үг: Мөнгөн дархан, түүх соёл, чадварын, соёлын өв
Удирдагч: С.Батцоож, МУБИС

Монголчуудын улс төрийн соёл, оролцооны зарим асуудал

Аюурзана Мөнхцэцэг**, Одгэрэл Гэрэлмаа*

Монгол Улсын Боловсролын Их Сургууль,

¹Боловсрол судлалын сургууль, Боловсрол судлал, арга зүйн тэнхим

²Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургууль, Нийгмийн ухааны тэнхим

odgerelgerelmaa@gmail.com

Хураангуй. Улс төрийн соёл нь улс төрийн үйл ажиллагаа, ардчиллын төлөвшил, нийгмийн институтын тогтвортой байдалд чухал нөлөө үзүүлэх бөгөөд иргэдийн улс төрийн боловсрол, хандлага, оролцоо тухайлбал ухамсар, ёс суртахуун, нийгмийн зан үйл, уламжлал зэрэгтэй нягт холбоотой ойлголт юм. Улс төрийн соёл бүрэлдэх, төлөвших орчин нөхцөл улс орон бүрд өөр, өөрийн гэсэн онцлогийг тээж байна. Жишээ нь Монголчуудад иргэдийн оролцооны идэвхтэй бус хэв шинж илрэх бөгөөд “шаардлагатай үед” л улс төрийн үйл ажиллагаанд оролцдог (намчирхах, намын эрх ашигт нийцүүлэх, оролцооны хувьд албадлагын гэх мэт), уламжлалт сэтгэлгээ, төрийг дээдлэх зэрэг үзэл хандлага илэрч байна. Иймд иргэдийн оролцооны олон төрөл боломжуудыг бий болгох, иргэдийн улс төрийн үйл ажиллагаанд оролцох ухамсар, зан үйл, боловсролыг нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна.

Түлхүүр үг: Улс төрийн соёл, улс төрийн соёлын хэв шинж, иргэдийн оролцоо

Удирдагч: Э.Гэрэлт-Од, МУБИС

Монгол хэлний хүндэтгэлийн утгат нэгжийн тухай

Yu Quan (Рашаан) **

Монгол Улсын Боловсрол Их Сургууль, Нийгэм, хүмүүнлэгийн
ухааны сургууль, Монгол хэлний тэнхим

870746173@qq.com

Хураангуй. Хүндэтгэлийн үг бол хүмүүсийн харилцаанаас үүсэж, хүн хүний хоорондох амьтай байдлыг зохицуулж байдаг учраас хүндэтгэл үг хэллэгийг судлах нь утга зохиолын хэм хэмжээнд найрсаг харилцаа, хэлний соёлын талыг илрүүлдэг гол арга болно. Энэ харилцаа бол хоёр хүний, бүлэг хүний, гэр бүлийн цаашлаад улс орны хоорондох албан болоод найрсаг харилцаанд илэрч, гол байртай байна. Тиймээс, хүндэтгэлийн утгатай үгийн илрэх хэлбэр, найруулга хэрэглээний талыг үндэслэл болгов. Монгол хэлний хүндэтгэлийн үг нь бүтээвэр, үг, өгүүлбэрээр хэрхэн илэрдэг болох ба мэндчилгээний үг, талархлын үг, ерөөлийн үг гэх мэт хүндэтгэлийн үгийг хам орчноос нь тодруулж үзнэ. Монгол хэлний хувьд хүндэтгэлийн үгийг судалгаанд нэгтгэж, хүндэтгэлийн утгатай үг найруулгын онол, хэрэглээний онцлогийг утга зохиолын хэм хэмжээнд тодруулах юм. Хам цагийн хүрээнд тодорхойлох, цуваа цагийн үүднээс баримт түүвэрлэх, задлан шинжлэх аргуудыг хэрэглэсэн.

Түлхүүр үг: Хүндэтгэл үг, хүндэтгэл, талархлын үг

Удирдагч: Ш.Баттөгс, МУБИС

Овгийн тамганы танин мэдэхүйн конструкц, тиг хэмжээг шинжих нь
(Археологийн олдворын жишээн дээр)

Гомбожав Лувсандандар**, Раднаабазар Гоцбаяр, Загд Баярмагнай
Монгол Улсын Боловсрол Их Сургууль, Дүрслэх урлаг, технологийн сургууль,
Дизайн зураг зүйн тэнхим, Дизайн зураг зүйн тэнхим
Luvsandandar.g@ulaanbaatar.edu.mn

Хураангуй. Археологийн олдворуудад суурилан овгийн тамганы танин мэдэхүйн конструкц, тэдгээрийн дүрслэл хэлбэр, тиг хэмжээс, харьцаа, гоо зүйн хэм хэмжээний үндсийг судлан, график үйлдлээр хэрхэн гүйцэтгэхийг танилцуулж байна. Овгийн тамганы гадаад хэлбэр, дотоод бэлгэдлийн систем нь нүүдэлчдийн сэтгэлгээ, танин мэдэхүйн өвийн илэрхийлэл тул язгуур дүрсний үүслийн ангилал, хөгжлийн зураглалыг схемчлэн харуулсан. Энэхүү судалгаа нь овгийн тамганы утга агуулга, бэлгэдэл, хувирлын тогтолцоог ойлгож, соёлын өвөөс суралцах, график дизайн болон бүтээлч үйлдвэрлэлийн сургалт, судалгаанд ашиглах боломжийг олгож байна. Иймд энэ чиглэлийн судалгаа нь ирээдүйн дизайнер, судлаач, сонирхогчдод зориулсан боловсролын чухал эх сурвалж болно.

Түлхүүр үг: Конструктив, харьцаа, гоо сайхан, төгс төгөлдөр
Удирдагч: Р.Гоцбаяр, З.Баярмагнай, МУБИС

Аригбөх хааны дүрийн судалгаа

Хасбаатар Содбилэг**, Раднаабазар Гоцбаяр
Монгол Улсын Боловсрол Их Сургууль, Дүрслэх урлаг, технологийн сургууль,
Дизайн зураг зүйн тэнхим, Дизайн зураг зүйн тэнхим
blgborjgn@gmail.com

Хураангуй. Монголын их хаадын дүр төрхийг судлахад олон төрлийн эх сурвалжийг ашиглах шаардлагатай. Нийгэм, төрийн бодлого, улс төр, шашин, гэр бүлийн нөлөө зэрэг хүчин зүйлийг шинжилснээр тухайн үеийн хүмүүсийн гадаад төрх, зан чанарыг бодитой тодорхойлох боломжтой. Мөн антропологи, генетикийн судалгаа нь хаадын удамшлын онцлогийг тодорхойлох чухал арга хэрэгсэл болдог. Үүнээс гадна, түүхэн зохиол, гэр бүлийн эш хөрөг, хадны зураг зэрэг эх сурвалжууд нь дүрслэх урлагийн уламжлалтай уялдуулан судлах боломжийг олгоно. Иймд Монголын эзэнт гүрний хаадын дүр төрхийг судлахдаа шинжлэх ухааны үндэслэлтэй, олон талт судалгааны арга зүйг ашиглах нь чухал юм.

Түлхүүр үг: Аригбөх хааны дүр, алтан ураг, антропологи, генетик
Удирдагч: Р.Гоцбаяр, МУБИС

БАЙГАЛИЙН УХААН

Шилмүүст ойн ангуучин шүрэн цохынхон (Coccinellidae)

Чинболд Энхзаяа^{1,2*}, Ганболд Уранбилэг², Доржсүрэн Алтанчимэг¹, Чулуунбат Сувдцэцэг³

¹ Шинжлэх ухааны академи, Биологийн хүрээлэн, ² Хятадын шинжлэх ухааны академи

³ Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Математик, Байгалийн ухааны сургууль,
Биологийн тэнхим
enkhzaya_ch@mas.ac.mn

Хураангуй. Бид Монгол орны шилмүүст ойд тархсан ангуучин шүрэн цохынхоны зүйлийн бүрэлдэхүүнийг хэвлэлийн мэдээ баримт, ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн шувуу, шавж судлалын лабораторийн сан хөмрөгт хадгалагдаж байгаа нийт 331 цэгийн 1188 бодгалийн шүрэн цохны дээж материалд тулгуурлан тогтоов. Судалгаагаар Монгол орны шилмүүст ойд тархалттай шүрэн цохны 4 дэд овгийн 6 трибийн 19 төрөлд хамаарах 27 зүйлийг бүртгэж, тархалтын мэдээнд тулгуурлан зүйл тус бүрийн тохиромжит амьдрах орчны зургийг хийж, тэдгээрийн Монгол орны ойн мужлалд тархах байдалд төсөө зүйн кластер, модны төрөлд тохиолдох байдал зэрэгт дүн шинжилгээ хийв.

Түлхүүр үг: Монгол орны ойн мужлал, тохиромжит амьдрах орчин, биоагент, махчин шавж
Удирдагч: Ч.Сувдцэцэг, МУБИС

Цайвар хүрэн болон бор хөрсний органик нүүрстөрөгчийн нөөц

Ганболд Ууганбат**

Монгол Улсын Боловсрол Их Сургууль, Математик, Байгалийн
ухааны сургууль, Газарзүйн тэнхим
uuganaa.key94@gmail.com

Хураангуй. Монгол орны жилийн дундаж агаарын температур 1940-2024 оны хооронд 2.55°C-аар дулаарч, нийлбэр хур тунадас 5.1%-иар бага зэрэг өссөн хандлагатай байна (УЦУОСМХ, 2024). Байгалийн бүс, бүслүүрийн ялгаа ихтэй өргөн уудам нутагтай, хуурай газрын эрс тэс уур амьсгалтай орны говь хээр, цөлөрхөг хээрийн бүс нь цөлжилтөд хүчтэй өртөж хөрсний үржил шимд давхарга нимгэрэх, хөрсний нүүрстөрөгчийн шингээлт багасах зэрэг сөрөг үр дагаврууд бий болсоор байна. Тиймээс хөрсөнд агуулагдах органик нүүрстөрөгч нь түүний шинж чанарыг сайжруулах, нөхөн сэргээх, үржил шим, бэлчээрийн болон таримал ургамлын ургацад нөлөөлөх гол хүчин зүйлийн нэг юм. Судалгаанд хамрагдсан талбайн Элсэнцэр цайвар хүрэн /P1/ нийт 53.84 т га⁻¹, цайвар хүрэн /P2/ хөрсөнд нийт 32.90 т га⁻¹, карбонаттай цайвар хүрэн /P3/ хөрсөнд нийт 97.01 т га⁻¹, карбонаттай цайвар хүрэн /P4/ хөрсөнд нийт 95.02 т га⁻¹, карбонаттай цайвар хүрэн /P5/ хөрсөнд нийт 75.08 т га⁻¹, карбонаттай цайвар хүрэн /P6/ хөрсөнд нийт 112.15 т га⁻¹ нөөцтэй байна. Харин Сайргархаг бор /P1/ хөрсний 0-75 см-т 49.54 т га⁻¹, Сайргархаг цайвар бор /P3/ хөрсний 0-80 см-т 36.71 т га⁻¹, Чулуурхаг бор /P5/ хөрсний 0-80 см-т 41.70 т га⁻¹, Чулуурхаг цайвар бор /P7/ хөрсний 0-75 см-т 20.78 т га⁻¹, Чулуурхаг карбонаттай бор /P8/ хөрсний 0-70 см-т 28.84 т га⁻¹, Сайргархаг бор /P12/ 0-120 см-т 48.41 т га⁻¹, Чулуурхаг цайвар бор /P14/ 0-85 см-т 20.10 т га⁻¹, Сайргархаг бор /P15/ хөрсний 0-55 см-т нийт 27.61 т га⁻¹ тус тус органик нүүрстөрөгчийн нөөцтэй байна. Тухайн хөрсний үе давхаргын зузаанаас хамаарч нөөцийн хэмжээ харилцан адилгүй байна. Цайвар хүрэн хөрс нь бор хөрснөөс 2-3 дахин их органик нүүрстөрөгчийн нөөцтэй байна. Энэ нь байгаль, нийгмийн олон хүчин зүйлээс нөлөөлөх боловч байгалийн бүс бүслүүр, рельеф, цаг уурын нөхцөл, хур тунадасны хуваарилалт,

хуурайшилт зэргээс хамаарч хөрсний хими, физик үйл явц харилцан адилгүй явагддаг болохыг нэг талаар илтгэж байна. Мөн бэлчээрийн даац, талхлагдсанаар хөрсний өнгөн үе давхарга доройтох үйл явц эрчимтэй явагдаж байна. Цаашид хөрсний органик бус нүүрстөрөгчийн нөөцийг тодорхойлох, чийгийн тогтвортой гүнийг тооцох, хөрсний зүсэлтийг тоон нэмэгдүүлж бүс нутгийн хэмжээнд тооцох шаардлагатай. Хөрсний зүсэлт хийн үе давхарга бүрийн нөөцийг гаргах, нийт нөөцийг тодорхойлох нь тухайн хөрсний потенциалыг тогтоохоос гадна агаар мандалд болон хуурай газрын нүүрстөрөгчийн хоорондын хамаарлыг тодорхойлоход чухал үүрэгтэй.

Түлхүүр үг: Цайвар хүрэн, бор, хөрсний органик нүүрстөрөгч, эзлэхүүн жин, чулууны агууламж
Удирдагч: С.Хадбаатар, МУБИС

Монгол орны гар далавчтаны (Chiroptera Blumenbach, 1779) эктопаразит

Монголхүү Давааням*
Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Математик,
Байгалийн ухааны сургууль, Биологийн тэнхим
davaanyam1221@gmail.com

Хураангуй. Монгол гар далавчтанд шимэгчлэн амьдарч буй эктопаразитын зүйлийн бүрдэл, тархалтыг судлах зорилгоор 8 аймгийн газар нутагт хамаарах 20 цэгээс гар далавчтаны 10 зүйлд хамаарах эзэн амьтдаас эктопаразитын 164 бодгаль цуглуулсныг ашиглан байнгын бэлдмэл бэлтгэн таньж тодорхойлж судалгааны материал болгон ашигласан. Бидний судалгаагаар 6 овогт хамаарах 20 зүйл эктопаразит бүртгэгдсэн бөгөөд эдгээрээс монгол орны хэмжээнд 1 төрөлд хамаарах 1 бодгаль хачиг гар далавчтанд шинээр бүртгэгдсэн бөгөөд тус судалгаа нь монгол орны биологийн олон янз байдал болон гар далавчтан ба бусад хөхтөн амьтдын зоонозын өвчний судалгаанд чухал ач холбогдолтой.

Түлхүүр үг: Гар далавчтан, эктопаразит, эзэн амьтан
Удирдагч багш: Ж.Ариунболд, МУБИС

Монгол бах /*Strauchbufo raddei*/-ын генетик олон янз байдал ба филогенетик

Рэнцэнжүгдэр Биндэрья*
Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Математик,
Байгалийн ухааны сургууль, Биологийн тэнхим
binderyarentsenjugder@gmail.com

Хураангуй. Монгол бах (*Strauchbufo raddei*)-ын генетик олон янз байдлыг судалж, тэдгээрийн филогенетикийн харилцаа хамаарлыг тогтоох зорилгоор Монгол орны зүүн, хойд, говийн бүсээс нийт 50 дээж цуглуулж, митохондрийн ДНХ-ийн D-лоор хэсгийг шинжилсэн. Судалгаагаар Монгол бахын генетик олон янз байдал ($Hd=0.81$, $Pi=0.0053$) өндөр байгаа нь тус зүйл дотор генетикийн ялгарал их, хувьслын чадавх өндөр байгааг илтгэж байна. Монгол бахын популяциуд филогенетикийн хувьд гурван бүлэгт хуваагдаж байсан бөгөөд энэ нь газарзүйн тусгаарлалтаас үүдэлтэй байж болзошгүй юм. Судалгааны үр дүн нь Монгол дахь Монгол бахын генетик бүтэц, түүний эволюцын түүхийг илүү тодорхойлох, хамгааллын менежмент, биологийн олон янз байдлыг хадгалах стратеги боловсруулахад шинжлэх ухааны үндэслэл болох ач холбогдолтой юм.

Түлхүүр үг: *Strauchbufo raddei*, генетик олон янз байдал, филогенетик, митохондрийн ДНХ, Монгол
Удирдагч багш: Г.Онолрагчаа, МУБИС